

**Дүрвэгсэдийн бүлэгт хамрагдах, цагаачлалын хүрээн дэх гадаад улсаас
ирсэн хүмүүст Чех улсад эрүүл мэндийн үйлчилгээгээр хангах талаархи
МЭДЭЭЛЛҮҮД**

Эмч болон бусад эрүүл мэндийн ажилтнууд танд чанартай эрүүл мэндийн үйлчилгээгээр хангах бэлтгэлтэй байна. Мөн орчуулагчийн тусламжтайгаар харьцахыг хичээнгүйлэх болно. Үзлэгийн үеэр хэлний ойлголцох, өөр дадал заншил зэрэг саад бэрхшээлүүдийг хамтран давж гарна гэдэгт бүрэн итгэлтэй байна. Харилцан бие биедээ итгэлцэх, сайн санааны үүднээс харилцан ойлгоцох, харилцан хүлээн зөвшөөрөх зэрэг нь хамгийн чухал зүйл байх болно.

Чех улсад эрүүл мэндийн хангамжийг хуулийн зүгээс 372/2011 тоот эрүүл мэндийн үйлчилгээний тухай хуулийн эмхтгэлээр мөрдлөг болгодог.

- Эрүүл мэндийн үйлчилгээг **зөвхөн таны чөлөөт сайн дурын зөвшөөрлөөр** хангах ба – тэгхээр өөр онцгой тохиолдлоос бусад үед (цаашид үз) та эрүүл мэндийн үйлчилгээг татгалзаж болно.
- Эрүүл мэндийн үйлчилгээг **танд сайн санаа энэрлийн** үүднээс хангах ба энэ нь Чех улсад зөвшөөрөгдсөн шинжлэх ухаан болон анагаах ухааны дүрэм журмаар мөрдөгдөх болно.

Эрүүл мэндийн үйлчилгээгээр хангагдаж байх үеийн таны эрх

- хүндэтгэлтэй, боловсон харьцаатай, хариуцлагатай, хувийн асуудлыг болон нууцлаг байдлыг баримтласан эрүүл мэндийн үйлчилгээгээр хангагдах
- тухайн эрүүл мэндийн үйлчилгээний явц, хэвтэж эмчлүүлэх хэсгийн дотоод дүрэм зэргүүдтэй танилцах
- эмнэлгийн дотоод дүрмийн дагуу, эрүүл мэндийн үйлчилгээний үйл ажиллагаанд саад болохгүйгээр өвчтөн өөрөө сонгосон гэр бүл, ойр төрлийнхөө хүмүүсээс эмчилгээ хийлгэж байх үедээ дэрэгдээ байлгах
- насанд хүрээгүй хүүхэд буюу хязгаарлагдмал хувийн эрхтэй (бие даалтгүй) хүн өөрийнхөө хууль ёсны төлөөлөгчөө (зарим тохиолдолд хуулиар сонгогдсон хууль ёсны төлөөлөгчөө), өсгөн тэжээн тэтгэгч, асран хариуцагч хүмүүсээ дэргэдээ байнга байлгах
- тухайн эрүүл мэндийн үйлчилгээг хангахад оролцож байгаа эрүүл мэндийн ажилтны болон мэргэжлийн ажилтнуудын нэрийг мэдэж болох
- эрүүл мэндийн үйлчилгээнд оролцоогүй хүмүүсийг дэргэдээ байлгахыг татгалзах
- эрүүл мэндийн үйлчилгээний явц болон хариуг бичгээр хүлээн авах
- эмнэлгийн хэвтэж эмчлүүлэх хэсэгт Чех улсад бүртгэлтэй шашны байгууллагаас эсвэл шашны үйл ажиллагааг гүйцэтгэдэг итгэмжлэгдсэн

хүний

зүгээс шашны асрамж эсвэл шашин шүтлэгийн дэмжлэг зэргийг хүлээн авах боломжтой ба энэ үйл ажиллагаа нь дотоод дүрэмтэй зохицолдсон, бусад өвчтөнгүүдийн эрх чөлөөг хөндөхгүйгээр явагдах ёстой; хэрэв амь насанд аюул учрах эсвэл эрүүл мэндээ хүндээр гэмтээх зэрэг тохиолдлуудад шашны байгууллагын айлчлалыг зөвшөөрөхгүй байж болохгүй (хууль дүрмэнд өөрөөр заагаагүй тохиолдолд).

Өвчтөний зөвшөөрөлгүйгээр зөвхөн зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн тусламжаар хангаж болно, энэ нь өвчтөнгийн эрүүл мэндийн байдал энэхүү зөвшөөрлийг хэлж чадахгүй тохиолдолд (өмнөх хүсэлтийг нь хөндөлгүйгээр) эсвэл сэтгэл мэдрэлийн хүнд өвчлөлт, хэрэв үүнийг эмчлүүлэхгүй тохиолдолд өвчтөнгийн эрүүл мэндийн байдалд хүнд хохирол үүсэж болзошгүй гэсэн тхиолдлуудад.

Өвчтөнгийн зөвшөөрөлгүйгээр эмчлэх (эмнэлэгт хэвтүүлэх), хэрэв

- o тусгаарлан хэвтүүлхийг заасан, хөл хорио карантин эсвэл нийтийн эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн дагуу
- o шалтгаангүйгээр болон онцгой байдлаар өөртөө болон өөрийнхөө ойр тойронд аюул учруулах мөн сэтгэл мэдрэлийн саатал илрэх эсвэл энэ өвчнөөр өвчилсөн эсвэл мансууруулах бодис хэрэглэсэн, өвчтөнгийн болон түүний орчин тойронд өөрөөр шийдвэрлэх боломжгүй нөхцөлд
- o түүний эрүүл мэндийн байдал хойшлуулашгүй шаардлагатай эрүүл мэндийн хангамж хэрэгтэй ч гэсэн энэ байдлаа өөрөө хэлэх чадваргүй тохиолдолд
- o насанд хүрээгүй хүүхдүүдийг, хувийн эрх нь хязгаарлагдмал (бие даалтгүй) хүмүүсийг, эдгээрийг зарим тохиолдолд тарчилган зовоож байсан, ашиглаж байсан, асаргаагүй хайхралгүй орхигдсон байж болзошгүй гэсэн тохиолдолд.